

III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

АЖЛЫН ДААЛГАВАР

<i>Төсөл боловсруулах үндэслэл</i>	Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 58 дугаар зарлиг, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар “Алсын хараа -2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх хөгжлийн бодлого, 2021 оны 12 сарын 30-ныөдрийн 106 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”, Монгол улсын Засгийн Газрын 350 дугаар тогтоол, Байгаль орчин аялал жуулчлалын яам, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын хамтран 100 сая мод тарьж ургуулах батламжийг үндсэлэн 2023 оны 11 дүгээр 15-ны өдөр гэрээ байгуулсан.
<i>Төслийн зорилго</i>	Булган аймгийн Орхон сумын 4 дүгээр баг Улаан эрэг газарт, Орхон голын эрэг дагуух бургасан шугуйд арчилгаа, цэвэрлэгээний ажлыг гүйцэтгэж, бургасны эх ургамлын плантаци буюу тайраадас бэлтгэх талбай байгуулан, уг талбайгаас 3 сая бургасан тайраадас бэлтгэх.
<i>Тавигдах шаардлага</i>	Боловсон хүчин Мод үржүүлэг, ойжуулалт нөхөн сэргээлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, 5-с доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа ба ойн салбарын инженертэй бургасан судаллаар ажиллаж байсан.
<i>Техникийн шаардлага</i>	Орхон голын эрэг дагуух 45 га бургасан шугуйд арчилгаа, цэвэрлэгээний ажлыг гүйцэтгэж, бургасны эх ургамлын плантаци буюу тайраадас бэлтгэх талбай байгуулан, уг талбайгаас 3 сая бургасан тайраадас бэлтгэх. <i>Бургасан плантаци байгуулах арга зүйг хэвлэмэл болон файл хэлбэрээр өгөх</i> <i>Онолын болон практик дадлага сургалт явуулах</i> <i>Ажлын тайланг 3 удаа өгөх</i> <i>Стандартын дагуу мөчир, тайраадас бэлтгэхэх зөвөлгөө зааварчилгаа өгөх</i>
<i>Төсөл боловсруулж дуусгах хугацаа</i>	2024.02.05-2024.05.31
<i>Хүлээлгэн өгөх ажлын бүрдэл</i>	<i>Ажлын тайлан / хэвлэмэл болон файл хэлбэрээр/</i> <i>Гарын авлага / хэвлэмэл болон файл хэлбэрээр/</i>
<i>Төлбөр тооцоо</i>	<i>Санхүүжилт Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-аас хийгдэх ба ажлын явцын тайлан хамгаалалт хийгдэж санхүүжилтын хуудас өгсөнөөс 30 хоногийн дараа хийгдэнэ. Тайланг 2 удаа хамгаална.</i>